



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны
саналын дагуу хийсэн аудитын тайлан*

УЛСЫН ЧАНАРТАЙ ЗАРИМ АВТО ЗАМЫН АЖЛЫН ҮР ДҮН



**Төрийн болон гүйцэтгэгч байгууллагууд шуурхай
ажиллаагүйгээс замын ажил удааширчээ**

Улаанбаатар хот
2011 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Ерөнхий зүйл	4
<i>Газрын захирал:</i> Д.Ганбилэг	Бүлэг 1 “Үнийн тохируулга хийх” гэрээний заалтыг хэрэгжүүлэх механизм бүрдээгүйгээс хөрөнгө оруулалтын өгөөж буурч байна	5
<i>Аудитын менежер:</i> Х.Баярмаа		
<i>Ахлах шинжээч:</i> У.Баярмаа	1.1 Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн хоёрдугаар ээлжийн 50 км авто замын хяналтын төсөв, нээлттэй тендер шалгаруулалтын баримт материал олохгүй байна	5
<i>Ахлах аудитор:</i> Ц.Гэрэл		
<i>Аудитор:</i> Д.Болормаа	1.2 Гэрээнд заасан ажлын хэмжээ, улсын төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийн хуваарь хоорондоо зохицохгүй байна	6
<i>Шинжээч:</i> Ц.Эрдэнэчулуун Ж.Эрдэнэ		
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	1.3 Замын ажил хугацаандаа эхлээгүй байна	6
www.mnao.mn	1.4 Захиалагчийн хяналт тавьж буй арга хэлбэр оновчгүй байна	7
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	1.5 “Үнийн тохируулга хийх” механизм бүрдээгүй байна	8
	1.6 Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 143 км авто замын ажил графикт хугацаанаасаа хоцорч байна	11
	Бүлэг 2 Захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудын хариуцлагагүйгээс зам хугацаандаа ашиглалтад орохгүй байна	13
	2.1 Гүйцэтгэгч сонгон шалгаруулалт 3 удаа хүчингүй болж тендерийн баримт бичиг олдсонгүй	13
	2.2 Ажил гүйцэтгэх гэрээний хугацаатай санхүүгийн эх үүсвэрийг уялдуулан төлөвлөж чадахгүй байна	14
	2.3 Ажил эхлэх бэлтгэл хугацаа хоцрон, зураг төсөлд алдаа гарсан ч хариуцлага тооцоогүй, захиалагч хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна	17

<i>2.4 Гүйцэтгэгчийн ИТА-ны хангамж, ажлын явц, чанар, зохион байгуулалт, хангалтгүй байжээ</i>	18
<i>2.5 Худалдан авах ажиллагааг хангалтгүй зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг оройтож байгуулан, хөрөнгө оруулалтыг оновчгүй төлөвлөжээ</i>	19
<i>2.6 Захиалагч, гүйцэтгэгчийн ажлын уялдаа муу, аль аль нь хариуцлагагүй ажиллаж иржээ</i>	20
Дүгнэлт	23
Зөвлөмж	24
Холбогдох байгууллагын санал	25
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	26

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЗТБХБ	Зам тээвэр, барилга, хот байгуулалт
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
ЗТАЖС	Зам тээвэр, аялал жуулчлалын сайд
АЗГ	Авто замын газар
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
ЭЦГ	Эрүүгийн цагдаагийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Аудитыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, ЗТБХБ-ын сайд Х.Баттулгын хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Дараах асуудлыг шалгаж дүгнэлт зөвлөмж гарган холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Өндөрхаан Сүмбэр чиглэлийн 2 дахь ээлжийн 50 км, 3 дахь ээлжийн 143 км замын ажлын явц
- Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн 27 км, Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замуудын ажлын явц, үр дүн

Аудитад ЗТБХБЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Зам, тээврийн бодлогын газар, АЗГ, Улаанбаатар АЗЗА, Төв АЗЗА ТӨХК-иуд, Насны зам, Эм Си Пи Си ХХК-иудыг хамрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2008-2011 оны төсвийн тухай хууль болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Холбогдох журам, зааврууд
- Ажил гүйцэтгэх гэрээнүүд

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны, хяналтын хэсгийн тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитыг хянан баталгаажуулах журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Бүлэг 1

“Үнийн тохируулга хийх” тухай гэрээний заалтыг хэрэгжүүлэх механизм бүрдээгүйгээс хөрөнгө оруулалтын өгөөж буурч байна

1.1 Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын төсөв, нээлттэй тендер шалгаруулалтын баримт материал олдохгүй байна

Өндөрхаан Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км, 3 дугаар ээлжийн 143 км хатуу хучилттай авто замуудыг барих ажил Монгол Улсын автозамын сүлжээг 2008-2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө болон 2008-2010 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан байна.

2007 онд Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км замын зураг төслийг Аварга зам ХХК зохиож, баталгаажуулах ажлыг ЭМ СИ ПИ СИ ХХК 2007 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн байна.

МУХС-гийн 2008 оны төсөвт уг төслийн эхний жилийн санхүүжилт болох 1050.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгч шалгаруулах үнэлгээний хороог 2008 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан байна.

Гэвч Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн хоёрдугаар ээлжийн 50 км авто замын хяналтын төсөв, нээлттэй тендер шалгаруулалтын баримт материал захиалагч ЗТБХБЯ, АЗГ-аас олдоогүй, яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж нүүсэнтэй холбон тайлбарлаж байна.

Зургийн гүйцэтгэгч Аварга зам ХХК хяналтын төсвийг АЗГ-т хүлээлгэн өгсөн гэсэн хариу өглөө.

ЗТАЖЯ-ны ТНБД-ын 2008 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 3/1567, ЗТАЖ-/хуучин нэрээр/-ын сайдын 2008 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 1/2403 зэрэг хэд хэдэн албан бичгээс үзэхэд нээлттэй тендер зарлаж, БНХАУ-ын Лин И хотын зам барилгын компани болон Геотрасс ХХК-ийн түншлэлийг шалгаруулсан байна.

Тендерт оролцогч Насны зам ХХК 2008 оны 5 дугаар сард Сангийн сайд Ч.Улаан, ЗТАЖ-ын сайд Р.Раш, ЗТАЖЯ-ны газрын дарга нарт болон Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газарт гомдол гаргасны дагуу шинжээчдийн баг томилон ажиллуулснаар Геотрасс ХХК ТБОНӨХБАҮХАТухай хуулийн шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гарч, уг тендерийг хүчингүй болгосон байна.

Ийнхүү ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 30.1.1-д заасны дагуу “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй” тул бүх тендерээс татгалзаж, Сангийн яамнаас хязгаарлагдмал тендер зарлах зөвшөөрлийг өгсөн байна.

Энэ дагуу хязгаарлагдмал тендер зарлаж Насны зам ХХК, Геотрасс ХХК, Монроуд ХХК, Ялгуусан ХХК-иудад тендерийн урилга хүргүүлсэн боловч зөвхөн Насны зам ХХК л санал ирүүлж, 2008 оны 9 дүгээр сарын 15-наас 2010 оны 8 дугаар сарын 30-ны хооронд замын ажлыг гүйцэтгэх 9,988.4 сая төгрөгийн гэрээ хийсэн байна.

1.2 Гэрээнд заасан ажлын хэмжээ, улсын төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийн хуваарь хоорондоо зохицохгүй байна

Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км хатуу хучилттай авто замын ажилд батлагдсан төсвийн хуваарь, компанийн гүйцэтгэсэн ажлыг оноор харуулбал:

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Санхүүжилт
2008 он	1,050.0	4,598.4	1,000.0
2009 он	1,000.0		1,000.0
2010 он	7,000.0	751.1	5,224.1
2011 он	3,290.1		
Нийт	12,340.1	5,349.5	7,224.1

2008-2009 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйцэтгэгч 4,598.4 сая төгрөгийн ажил хийсэн байхад энэ хугацаанд 2,050.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан нь хийсэн ажлаас 2.3 дахин бага байна.

Өөрөөр хэлбэл автозамын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасан ажил болон төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийн хуваарь харилцан уялдаагүй байна. Энэ нь хөрөнгө оруулалтыг олон төсөлд хүртээх байдлаар хуваарилж байгаагийн илрэл бөгөөд гүйцэтгэгчийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлж байна.

1.2 Замын ажил хугацаандаа эхлээгүй байна

Гэрээнд заасны дагуу гүйцэтгэгч байгууллага тодотгосон ажлын хөтөлбөрийг 2008 оны 9 дүгээр сарын 22-ны дотор ирүүлэх ёстой байсан.

Гэтэл энэ хугацаанд АЗГ-аас улаан шугам хүлээлгэж өгсөн, 2009 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 1/112 дугаар албан бичгээр Насны зам ХХК-д ажлын хуваарийг загварын дагуу хийж 4 дүгээр сарын 27-ны дотор ирүүлэх, улмаар 5 дугаар сарын 1-ний дотор замын барилгын ажил эхлүүлэхийг мэдэгдсэнээс үзэхэд тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй, замын ажил хугацаандаа эхлээгүй байна.

Гүйцэтгэгчийн зүгээс уг төсөл дээр 11 инженер, 82 машин механизм ажиллуулах боломжтой гэж тендер ирүүлсэн ч 2009 оны 9 дүгээр сард 109 хүн, 2010 оны 6-7 дугаар сард 76 хүн, 9-10 дугаар сард 57 хүн, үүний дотор 3-11 инженер, 22-50 машин тоног төхөөрөмж ажиллаж байжээ.

Насны зам ХХК ажиллах хүч болон машин механизмыг тендерийн баримт бичигт заасан хэмжээнд хүргэж ажиллуулаагүй нь Булган-Уньтын 74 км авто замыг 2010 оны 11 дүгээр сард, Өмнөговь аймагт Энержи ресурс ХХК-ийн 34.6 км авто замын ажлыг 2010 оны 5 дугаар сараас 2011 оны 9 дүгээр сарын хооронд гүйцэтгэсэнээс шалтгаалжээ.

Гэрээний ерөнхий нөхцөл 61.1-д “гэрээ цуцлах үед захиалагчид төлөх нийт төлбөр нь гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно” гэж заасан байна.

Гэрээ цуцлах үеийн тооцоог хүснэгтээр харуулбал:

		сая төгрөгөөр
Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Зөрүү үлдэгдэл
7,224.1	5,349.4	1,874.6

2010 оны 7 дугаар сард Голомт банкнаас урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулснаар 2,100.0 сая төгрөгийн урьдчилгаа авсан бөгөөд 1,874.6 сая төгрөгийн урьдчилгаанд гүйцэтгэл ирээгүйгээс суутгаагүй үлдсэн бөгөөд үүнд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт бичлээ.

1.4 Захиалагчийн хяналт тавьж буй арга хэлбэр оновчгүй байна

АЗГ-аас 2009 оны 9 дүгээр сарын 24, 2010 оны 6 дугаар сарын 3, 2010 оны 7 дугаар сарын 19-ний өдрүүдэд хяналтын баг томилсон, хяналтын хэсэг ажиллах журмын 3.1¹-д зааснаар хэсгийн бүрэлдэхүүнд талбайн байцаагч инженер ажиллах ёстой ч мэргэжлийн инженерийн хүрэлцээгүйгээс ажиллаагүй байна.



Зам шалгах явцад 2 дугаар ээлжийн 50 км замд хоорондоо ойрхон 57 карьер буюу дунджаар 900 метр тутамд 1 карьер байгаа нь байгаль орчны хяналт сул, Авто замын тухай хуулийн 4-р бүлгийн 13.4² дэх хэсэгт заасныг зөрчсөн байна.

Хяналтын хэсгийн 6-10 сарын тайланд барилга угсралтын ажлын гүйцэтгэл гаргах, үндсэн материалын хэрэгцээ, зарцуулалтын байдал, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудал, санал, зөвлөмж зэрэг гол үзүүлэлт тусгагдаагүй байна.

Хяналтын хэсэг Насны зам ХХК-д 2010 оны 6-10 саруудад 9 удаа албан шаардлага өгч, талбайн уулзалтыг 6 удаа хийж үүрэг чиглэл өгсөн зэргээс үзэхэд 120 хоногт хийгдсэн ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьсан гэж үзэх боломжгүй, харьцангуй цөөн байна.



Талбайн уулзалтаар ул хөрсийг солих, карьерын хөрс хуулалтыг дутуу хийснээс хөлдөлтөөс хамгаалах үед шаардлага хангахгүй материал орсон талаар яригдаж байжээ.

¹Авто замын хяналт, судалгааны төвийн захирлын 2005 оны 4 сарын 21-ний өдрийн 40 дугаар тушаалын хавсралт 3.3.1-д Зам гүүрийн барилга, засварын ажлын хэмжээнээс хамааран хяналтын хэсэг нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллана.ҮҮНД:

- Хяналтын хэсгийн ахлагч буюу хяналтын инженер
- Талбайн байцаагч инженер /Гүйцэтгэх ажлын хэмжээнээс тоог тогтооно/
- Материалын инженер
- Хэмжилтийн инженер

² Авто замын тухай хуулийн 4-р бүлэг 13.4 Иргэн, хуулийн этгээд авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлан хамгаалахдаа хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт, техник технологи, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй

1.5 “Үнийн тохируулга хийх” механизм бүрдээгүй байна

Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын гүйцэтгэгч Насны зам ХХК-тай хийсэн гэрээний тусгай нөхцөлийн 48-д ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.4³-д заасныг үндэслэн “үнийн тохируулга хийж болно, зөвхөн голлох түүхий эд болох битум, шатах тослох материал, цемент, арматур зэрэгт үнийн тохируулга хийнэ” гэж заажээ.

Гэвч дээрх заалтыг хэрэгжүүлэх механизм байхгүй, үнийн өсөлтийн улмаас гүйцэтгэгчид олгох “үнийн тохируулга”-ын хөрөнгийн эх үүсвэр тухайн жилд улсын төсөвт тусгагдаагүй байсан тул гэрээнд заасан үүргээ захиалагч биелүүлж чадаагүй байна.

Үүний улмаас хөрөнгө оруулалтын хэрэгжилт удааширч ихээхэн хугацаа алдсан байна. Тухайлбал, Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын гүйцэтгэгч 2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр үнийн зөрүү нэхэмжилсэн 238 дугаар албан бичгийг АЗГ-т ирүүлсэн байна.

ЗТБХБ-ын сайдын 2010 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 79 дүгээр тушаалаар үнийн өсөлтийн улмаас гэрээний үнийг нэмэгдүүлэхийг хүссэн компаниудын гэрээний үнэд мониторинг хийхийг ТНБД-д үүрэг болгосон байна.

Уг тушаалыг хэрэгжүүлэх үүднээс ЗТБХБЯ-ны ТНБД-ын 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 102 дугаар тушаалаар үнийн өсөлтийн асуудлыг судалж шийдвэрлэх ажлын хэсэг байгуулж, уг ажлын хэсгийн дүгнэлтийг Сангийн яамны ТНБД-д 2010 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 4/3824 дүгээр албан бичгээр хүргүүлжээ.

Үүнд нийт 36 компанид 33,185.8 сая төгрөгийг үнийн зөрүүд олгох тооцоо гарч, Насны зам ХХК-ийн Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын ажилд (2009 оны үнийн зөрүүд 701.8 сая, 2010 оны үнийн зөрүүд 2,203.5 сая төгрөг) 2,904.5 сая төгрөг тооцоологдсон байна.

Үүний зэрэгцээ УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2010 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “2009 оны үнийн зөрүүг судалж 2010 оны төсвийн тодотголд тусгах санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Р.Будаар ахлуулан байгуулж, нийт 31 компанид 4,699.01 сая төгрөгийг 2009 оны үнийн зөрүүд олгох нь зүйтэй гэсэн дүгнэлт гарчээ.

Үүний дотор Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км замын ажилд Насны зам ХХК-д 2009 оны үнийн зөрүүд 701.8 сая төгрөг олгохоор тусгагдсан байна.

Гэвч эдгээр ажлын хэсгийн санал дүгнэлт Насны зам ХХК-ийн гүйцэтгэж байгаа хоёрдугаар ээлжийн 50 км авто замын ажлын хувьд хэрэгжээгүй байна.

³40.4: Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараахь тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно: 40.4.1. хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн; 40.4.2. суурь үнэ огцом өөрчлөгдсөн.


Гүйцэтгэгч Насны зам ХХК “уг ажлыг дуусгахад төсөвт өртөг нь хүрэхгүй” үндэслэлээр гэрээ цуцлах хүсэлтийг 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2/226 дугаар албан бичгээр АЗГ-т ирүүлж, 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр захиалагч, гүйцэтгэгчийн хамтарсан ажлын хэсэг ажилласан байна.

Ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу ЗТБХБ-ын сайдын 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 115 дугаар тушаалаар гэрээг цуцалсан байна.

АЗГ-ын даргын 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/25 дугаар тушаалаар Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын хийгдсэн ажлыг хүлээн авах, үлдэгдэл ажлын тоо хэмжээг тогтоох, барилгын талбайг чөлөөлүүлэх ажлын хэсгийг томилсон байна.

Ажлын хэсгээс гүйцэтгээгүй ажлын тоо хэмжээг тодорхойлж, уг замыг дуусгахад шаардагдах төсвийг АЗГ-ын мэргэжилтнүүд 12.6 тэрбум төгрөгөөр тогтоож 2012 оны улсын төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн байна. Харин ажлын хэсэг гүйцэтгэсэн ажлын хэмжээг олгосон санхүүжилттэй уялдуулсан дүгнэлт гаргаагүй байлаа.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн “үнийн тохируулга”-ыг хийх хүсэлтийг сайдын тушаал болон УИХ-ын Байнгын хороодын тогтоолоор ажлын хэсэг байгуулан ажиллуулах, холбогдох газруудаар хянуулж, хэлэлцүүлэх, дараа оны төсвийн төсөлд тусган УИХ-аар хэлэлцэн батлах, түүний дараа нэмэлт санхүүжилт олгох хүртэл 2-3 жил өнгөрч замын ашиглалтаас бий болох ёстой хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч байна. Тухайлбал, Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын хувьд гүйцэтгэгч 2009 онд үнийн зөрүү нэхэмжилж, 2010 онд гэрээ цуцлах хүсэлт гаргасан, 2011 онд гэрээ цуцалж, шинэ төсөвт өртгөөр 2012 оны төсвийн төсөлд тусгагдаж байгаа нь санхүүжилт шийдэгдтэл 3 жил, дахин тендер зарлан, гүйцэтгэгч сонгож ашиглалтад оруултал 2 жилээс доошгүй хугацаа шаардагдахаар байна. Энэ үйл явцыг схемээр харуулбал,



Замын барилгын ажилд үнийн өсөлтийн зөрүү тооцон олгож байгаа өнөөгийн жишиг үндэсний компаниудын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Олон улсын замчдын нийгэмлэгээс сүүлийн жилүүдэд мөрдөх болсон жишгээр магадлашгүй ажлын зардлыг давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэх магадлашгүй ажлын зардал, үнийн өсөлтийн магадлашгүй зардал гэж ангилах болжээ.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Ярант-Улаан байшинтын чиглэлийн 700 км авто зам болон Кувейтийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Уньт-Тариалангийн чиглэлийн авто замд уг аргачлалаар гэрээний загварыг гаргасан байна.

Энэ жишгийн дагуу эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор АЗГ-аас "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, гүүрийн барилга, засварын ажлын гэрээний үнэд магадлашгүй зардлыг тусган тооцох" журмын төсөл боловсруулж, 2010 оны 12 дугаар сард ЗТБХБЯ-д хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна.

Үнийн тохируулга хийх хөрөнгийн эх үүсвэрийг "Засгийн газрын тусгай сангийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар "Хөрөнгө оруулалт хөгжлийн сан" болон "Эрсдэлийн сан"-гийн аль нэгний бүрэлдэхүүнд хамааруулж болохоор байна.

Ингэсэн тохиолдолд хөрөнгө оруулалтын төслүүдийн үнийн тохируулгын нэгдсэн санг салбарын сайд, Сангийн сайдын хамтарсан шийдвэрээр зарцуулдаг журамд шилжих боломжтой юм.

"Үнийн тохируулга"-ыг тухайн үед нь хийж чадсан бол Насны зам ХХК-д Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замын ажлын гэрээнд заасны дагуу гол нэр төрлийн материалын үнийн өсөлтөд 1.4-2.2 тэрбум орчим төгрөг зарцуулахаар байжээ.

ТБОНӨХБАҮХАТухай хууль, гэрээний заалтын дагуу үнийн тохируулгын санхүүжилт олгохдоо УИХ-аар батлуулж ирэх жилийн төсөвт тусгадаг өнөөгийн тогтолцооны улмаас уг замын өртөг олон дахин нэмэгдэж 2012 оны улсын төсвийн тухай хуулиар 12.6 тэрбум төгрөгөөр дуусгахаар батлаад байна.

Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагууд шуурхай арга хэмжээ авч чадаагүйгээс болоод хоёрхон жилийн өмнө 2.2 тэрбум төгрөгөөр хийчих байсан ажлыг одоо 6 дахин их үнээр гүйцэтгүүлэхэд хүрч байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хооронд хийсэн гэрээний адил уян хатан хандах боломж төрийн яам, агентлагт бүрдвэл авто замыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах боломж нэмэгдэх юм. Энэ нь улс орны эдийн засагт ч чухал ач холбогдолтой.

Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 2 дугаар ээлжийн 50 км авто замыг гэрээ ёсоор 2010 онд ашиглалтад оруулсан бол зөвхөн тээвэр ашиглалтын болон зам хэрэглэгчдийн зардлаас л гэхэд 200 орчим сая төгрөгийн шууд бус хэмнэлт гарах байсан тооцоо гарчээ.

1.6 Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 143 км авто замын ажил графикт хугацаанаасаа хоцорч байна

Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр баригдаж байгаа Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 143 км замын ажилд 2010 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр үнэлгээний хороо байгуулагдаж, нээлттэй тендерийн баримт бичгийг ЗМЗ ХХК, Дорнод автозам ХХК, Насны зам ХХК-иуд худалдаж авсан байна.

2010 оны 3 дугаар сарын 9-ний өдөр тендер нээхэд зөвхөн Насны зам ХХК, БНХАУ-ын Шандун мужийн Литун зам барилгын компанийн түншлэл 54,331.5 сая төгрөгийн санал ирүүлж, 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 2012 оны 11 дүгээр сарын 1-ний хугацаанд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр баригдах авто замын барилгын ажлын захиалагчийн хяналтыг ЭМ СИ ПИ СИ ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2011 оны 3 дугаар сарын 28-ны өдөр 827.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Зөвлөх ЭМ СИ ПИ СИ ХХК 2011 оны 6 дугаар сараас ажлаа эхэлж, хяналтын ажлын эхлэлийн тайланг 2011 оны 7 дугаар сард АЗГ-т ирүүлжээ. Гүйцэтгэгч Насны зам ХХК 2010 онд замын чиг сэргээх ажлын 20.9, ул хөрсний ажлын 25.7, далангийн ажлын 26.0, ухмалын ажлын 61.0 хувийг тус тус хийж гүйцэтгэсэн дүнтэйгээр зөвлөх компанийн хяналтад шилжсэн байна.

2011 онд 40 км замыг хучих төлөвлөгөөтэйгээс 10 дугаар сарын 30-ны байдлаар далангийн ажил 61.8 км, хөлдөлтөөс хамгаалах үе 46 км, буталсан чулуун суурь 34 км, асфальт бетон хучилт 12 км, дугуй болон дөрвөлжин хоолой 36 ширхэг хийгдэж, энэ онд төлөвлөсөн хучилтын ажил 30.0 хувийн гүйцэтгэлтэй, графикаас сар илүү хугацаагаар хоцорч байна.



Гэрээний тусгай нөхцөлд зааснаар гэрээ батлагдсанаас хойш 14 хоногт буюу 2010 оны 7 дугаар сарын 19-ний дотор ажил эхлэх ёстой боловч 9 дүгээр сард эхэлсэн байна. Дорнод аймгийн Булган, Хөлөнбуйр сумдаас газар олгох захирамж удаж гарснаас ажил эхлэх зөвшөөрөл авах хугацаа хойшилсон байна.

2011 оны хувьд 5 дугаар сарын 1-нээс ажил эхлэх ёстой боловч 5 сарын 15-наас талбайд ирж, 2011 оны 6 дугаар сарын 16-ны байдлаар ажил эхлээгүй, материалыг талбайд татаагүй байжээ. АЗГ-аас 6 дугаар сарын 25-ны дотор ажлыг эхлүүлэх шаардлага хүргүүлсэн байна.

Ажил эхэлсэн ч ажиллах хүч, машин, тоног төхөөрөмжийг төлөвлөгөөнд заасан хэмжээнд хүргэж ажиллуулаагүй байна.

Гүйцэтгэгчийн машин, тоног төхөөрөмж, ажиллах хүчний хангамж:

Хангамж		5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар
Машин тоног төхөөрөмжийн	төлөвлөгөө	60	70	111	120	130	162
	гүйцэтгэл	0	0	64	78	78	
	Хувь			57.6	65	60	
Ажиллах хүчний	төлөвлөгөө	131	153	249	276	233	234
	гүйцэтгэл	0	117	140	175	175	
	Хувь			56.2	63.4	75.1	

Эх сурвалж: Зөвлөхийн явцын тайлан, АЗГ-ын даргаар батлуулсан ажлын төлөвлөгөө

Энэ нь Булган-Уньтын төсөл дээр ажиллаж байсан машин тоног төхөөрөмж нэмж ирж байгаа, мөн Улаанбаатараас машин техник, хүн хүч татах гэж байгаа, гадаадаас оруулж ирэх ажиллах хүчний визний асуудлаас шалтгаалан саатсан гэж гүйцэтгэгч тайлбарлаж байна.

Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 143 км авто замын гүйцэтгэгч Насны зам ХХК “гэрээний тусгай нөхцөлийн 34-д⁴ -д заасны дагуу захиалагчийн хяналтын зардалд шилжүүлэх зардлаас 2011 оны 7 дугаар сард 120.0 сая төгрөг шилжүүлсэн нь төлөх ёстой мөнгөний 20.0 орчим хувь болж байна. Энэ нь захиалагчийн хяналтын ажлыг хэвийн явуулахад хангалтгүй юм.

⁴захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд гарын үсэг зурсанаас хойш 28 хоногийн дотор захиалагчийн дансанд эхний жил нийт дүнгийн 40 хувийг шилжүүлнэ. 2 ба 3 дахь жилийн 4 дүгээр сарын 1-нээс өмнө 30 хувийг тус тус шилжүүлнэ”

Бүлэг 2

Захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудын хариуцлагагүйгээс зам хугацаандаа ашиглалтад орохгүй байна

2.1 Гүйцэтгэгч сонгон шалгаруулалт 3 удаа хүчингүй болж тендерийн баримт бичиг олдсонгүй

Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ЗТАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 5 дугаар тушаалаар байгуулжээ.

Үнэлгээний хороо, тендерт оролцсон 11 аж ахуйн нэгжээс Улаанбаатар АЗЗА ТӨХК, Чайл Ган ХХК-ийн түншлэл, Монроуд ХХК -ийг шаардлага хангасан тендер ирүүлсэн гэж дүгнэжээ.



Сангийн яамнаас үнэлгээний хорооны тайланг хянаж Монроуд ХХК 21,0 тэрбум төгрөгийн өр төлбөртэй, захиалагчийн тавьсан тусгай шаардлагыг ажлын графикт тусгаагүй, мэргэжлийн ажиллах хүч, тоног төхөөрөмжийн жагсаалтгүй, үнийн санал нь захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 16,6 хувиар өндөр гэж дүгнэн ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 30.1.3⁵ дахь заалтын дагуу тендерээс хассан байна.

Харин Улаанбаатар АЗЗА ТӨХК, Чайл Ган ХХК-ийн нээлттэй тендерийн шалгаруулалтад ирүүлсэн үндсэн бичиг баримт ЗТБХБЯ-ны архивт байхгүй, Эрүүгийн цагдаагийн газарт шилжүүлсэн гэсэн тайлбарыг хариуцсан ажилтан өгсөн.

Гэтэл ЭЦГ-ын 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 9ж/4825 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтад оролцсон 11 байгууллагын тендер шалгаруулалтын материал ЭЦГ болон Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн тоо бүртгэлд бүртгэгдээгүй гэсэн хариуг ирүүлсэн байна.

Тендер 3 удаа хүчингүй болж, үнэлгээний хороо 1-2 хоногийн зайтай 7 удаа хуралдсан зэргээр замын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт болон гэрээ байгуулах хугацаа хойшлогдсон байна.

⁵ Шаардлагад нийцсэн тендер нь захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд тендерээс татгалзана.

2.2 Ажил гүйцэтгэх гэрээний хугацаатай санхүүгийн эх үүсвэрийг уялдуулан төлөвлөж чадахгүй байна

Монгол Улсын авто замын сүлжээг 2008-2020 он хүртэл нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх ерөнхий болон дунд хугацааны төлөвлөгөөг олон улсын байгууллага боловсруулсныг тухайн үеийн засгийн газар сайшааж, салбартаа мөрдлөг болгож байна.

Авто замын чиглэлийг ач холбогдлын дарааллаар ангилж үе шаттайгаар хэрэгжүүлэх энэ төлөвлөгөөнд Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн авто зам барих ажил дараах байдлаар тусгагдсан байна.

Бодлогын баримт бичиг	Боловсруулсан байгууллага	Заалт, авто замын чиглэл
Монгол улсын авто замын сүлжээг дунд хугацаанд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	АХБ-ны тусламжийн хөрөнгөөр 1993-1994 онд Английн Скот Вилсон Крикпатрик, Энэтхэгийн Интерконтиненталь Консалтинг энд Технократс зөвлөх компани	22. Арвайхээр-Баянхонгорын чиглэлд хайрган зам барих
Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 1999 онд боловсруулсан, тухайн үеийн засгийн газар сайшаасан	3. Арвайхээр-Баянхонгор чиглэлд авто зам барих
МУ-ын авто замын сүлжээг 2020 он хүртэл хөгжүүлэх төсөөлөл	МУ-ын авто замын сүлжээний гол гол чиглэлүүдийн барьж гүйцэтгэх дарааллыг тусгасан	3. Арвайхээр-Баянхонгор 171.5 км
МУ-ын авто замын сүлжээг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	Австралийн Смек интернейшнл компани 2007 онд боловсруулсан	24. Арвайхээр-Баянхонгор 208 км (7,4-үнэлгээ)
Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол	2007-2015 онуудад Бүсийн болон аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох

Дээрх чиглэлийн авто замыг барих ажлыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан байдлыг харуулбал;

Хөтөлбөр, төлөвлөгөө	Батлагдсан огноо	Заалт, авто замын чиглэл
МУ-ын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр	УИХ-ын 2009 оны 1 дүгээр тогтоол	2.4.17 “Мянганы зам” төслийн ажлыг эрчимтэй үргэлжлүүлэн аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлнэ
МУ-ын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	УИХ-ын 2009 оны 79, ЗГ-ын 2010 оны 69 дүгээр тогтоол	8.24 Арвайхээр Баянхонгорын чиглэлийн автозамыг барьж дуусгах
МУ-ын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	УИХ-ын 2010 оны 45, ЗГ-ын 2010 оны 302 дугаар тогтоол	7.7 Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн төвийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох

Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажлыг 9,516.5 сая төгрөгт гүйцэтгэх Улаанбаатар АЗЗА ТӨХК, Чайл Ган ХХК-ийн түншлэл 2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр эхлэн, 2009 оны 11 дүгээр сарын 1-нд ашиглалтад оруулахаар ЗТАЖЯ-тай гэрээ байгуулсан байна.

Гэрээний хугацаанд ажил дуусаагүй тул гэрээг 2010 оны 10 дугаар сарын 30, 2011 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл 2 удаа сунгажээ.

Замын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан болон санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.

Он	Хөрөн- гийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэх хугацаа	Тухайн онд төлөвлөгдсөн			Санхүү- жилтийн дүн	Гүйцэтгэл
				Төсвийн төсөлд өгсөн санал	Батлагд- сан төсөв	Төсвийн тодотго- лоор		
2008	МУХС	10,000.0	2008-2009	5,000.0		10,000.0		
	УТ				500.0	1,500.0	1,500.0	2,237.6
2009	УТ	9,516.5	2008-2010	3,000.0	1,950.0	1,950.0	1,950.0	1,601.7
2010	УТ	9,516.5	2008-2010	6,066.5	6,066.5	6,066.5	2,957.9	1,083.8
2011	УТ	9,516.5	2008-2011	3,765.5	3,766.5		2,259.2	2,259.2

УТ-Улсын төсөв

ЗТАЖС-ын 2007 оны 186 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар авто зам, замын байгууламж барих нормативт хугацааг тогтоож 2008 оноос мөрдөхөөр баталжээ.

Энэ нормоор дээрх 50 км хатуу хучилттай авто замыг 22 сард барьж 2011 оны 5 дугаар сард дуусахаар байсан атал 14 сард барихаар, мөн 2008 онд нийт замын ажлын 40 хувийг, үлдэх хэсгийг 2009 онд гүйцэтгэхээр график төлөвлөгөө гаргасан байна.

Гэвч улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 2008, 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд гэрээний үнийн дүнгийн 36.3 хувийг төлөвлөсөн бөгөөд барилгын ажлын үргэлжлэх хугацаатай хөрөнгө оруулалтыг уялдуулан ажил гүйцэтгэх гэрээ хийгээгүй байна.

Түүнчлэн 2008-2010 онд зам, барилгын үндсэн материалын нэгжийн үнэ ханш 2007 оныхоос эрс өссөн бөгөөд үүнд тухайлбал, арматур төмрийнх 13.4-39.2 хувь, битумынх 2.0-2.1 дахин, дизель түлшнийх 1.5-2.1 дахин өссөн байна.

Энэ эрсдэлийг захиалагч, гүйцэтгэгчийн зүгээс урьдчилан тооцоогүй нь гэрээний үнийн дүнд багтаан ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болгосон байна.

Дээрх нөхцөл байдал нь гүйцэтгэгч компанийг алдагдалд оруулан ажил жигд явагдах боломжгүй болгож улмаар гэрээний хугацааг сунгах шаардлага үүсчээ.

Энэ тухай Улаанбаатар АЗЗА ТӨХК захиалагчид мэдэгдсэн боловч асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Гүйцэтгэгч Улаанбаатар АЗЗА ТӨХК, Чайл Ган ХХК-ийн түншлэл 2008 оны хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнөөс 737.5 сая төгрөгийн ажлыг илүү гүйцэтгэж, дараа оны 2 дугаар сарын 13-нд санхүүжилтээ авсан байна.

2009 онд 1,601.7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл гаргасан буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 348.3 сая төгрөгөөр дутуу ажил хийж, 390.3 сая төгрөгийн санхүүжилтийг дараа онд гүйцэтгэгчид шилжүүлсэн байна.

2010 онд 1,083.8 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь батлагдсан төлөвлөгөөнөөс 4,982.7, олгосон санхүүжилтээс 1,874.1 сая төгрөгөөр дутуу бөгөөд тухайн онд авсан урьдчилгаагаа төлж чадаагүй байна.

Захиалагч 2008-2010 онд урьдчилгаа санхүүжилтийг гүйцэтгэгчид гэрээний дагуу бүрэн төлж байжээ.

Гэрээний тусгай нөхцөлийн 44-т нөхөн төлбөр хийх шаардлагагүй, 48-д үнийн тохируулга хийхгүйгээр тусгасан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40.4.1⁶, 40.4.2⁷-т заасныг мөрдөөгүй байна.



Захиалагч санхүүжилтийг удаадгаас ажил саатдаг тухай гомдол гүйцэтгэгч байгууллагуудаас их гарч байжээ.

Үүнийг тодруулахаар Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэлийг хянасан, санхүүжилтийг олгосон хугацааг түүвэрлэн үзэв.

Огноо	Гүйцэтгэлүүд	Хугацаа /хоногоор/				Гүйцэтгэл бичсэнээс гүйцэтгэгчийн дансанд санхүүжилт орох хүртэл
		Гүйцэтгэл хянуулсан		Санхүүжүүлсэн		
		Гүйцэтгэгчээс ЗТБХБЯ-нд	ЗТБХБЯ-наас СЯ-нд	СЯ-наас ЗТБХБЯ-нд	ЗТБХБЯ-наас гүйцэтгэгчид	
2008	№2	22	27	2	2	53
	№3, он дамжсан	85	18	1	1	105
	№4	26	12	5	1	44
2009	№5	23	7	0	18	48
	№6, он дамжсан	122	14	0	1	137
2010	№7	13	6	1	1	21
	№8	20	13	1	3	37

Санхүүжилтийг өдөрт нь шилжүүлснийг 0 гэж тэмдэглэв.

⁶ 40.4.1 хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн

⁷ 40.4.2 суурь үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд гэрээний үнэнд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно

2008-2010 онд ажлын гүйцэтгэл бичсэнээс хяналтын шатаар дамжин гүйцэтгэгчийн дансанд санхүүжилт орох хүртэл нийт 21-137 хоног, үүнээс, захиалагчаар 13-122 хоног, Сангийн яамаар 6-27 хоногийн хугацаанд гүйцэтгэлийг хянуулсан байна.

Ажлын гүйцэтгэлийг хянахад хугацааны ихэнх буюу 61.9-89.0 хувийг зарцуулсан байх тул энэ шат дамжлагыг шуурхай болгох шаардлагатай байна.

2.3 Ажил эхлэх бэлтгэл хугацаа хоцрон, зураг төсөлд алдаа гарсан ч хариуцлага тооцоогүй, захиалагч хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна

Захиалагч замын улаан шугамыг гэрээт хугацаанаас ажлын 16 хоногийн дараа гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, ажил эхлүүлэх зөвшөөрлийг ажлын 42 хоногийн дараа МХЕГ-аас олгосон байна.

Замын ажлын зураг төслийг Мон-Аз ХХК гүйцэтгэсэн байна.



Ажил гүйцэтгэх явцад геологийн судалгаа, геодезийн хэмжилт хангалтгүй хийгдсэн, автозамын норм дүрмийг баримтлаагүйгээс боловсруулсан зураг төсөл бодит байдлаас зөрсөн зэргээс шалтгаалж барилгын ажил тодорхой хугацаагаар саатаж байсан ч зураг төслийн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна. Тухайлбал;

- Репер 15-23 хүртэл өндөр 0.2-1.25 м, замын трассын дагуух хар өндрүүд 0.2-1.25м, ПК257+85, ПК261+97 цэг дээр хоолойн хар өндөр 0.326м, 0.282м-ээр зургаар өгөгдсөн өндөржилтөөс зөрснийг Кадсурвей ХХК 2008 оны 8 дугаар сарын 8-10 хүртэл нивелирдлэгийн шалгалт хийж тогтоосон,
- Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвийн дэргэдэх уулзвар дээр замын дагуу автозамын норм дүрмийн шаардлагыг хангахгүй огцом эргэлт гарсан тул аймгийн МХГ-аас 2009 оны 5 дугаар сарын 4-нд зураг төсөлд өөрчлөлт оруулах хүсэлтийг захиалагч АЗГ болон зураг төслийн байгууллагад гаргасан,
- Баянхонгор аймгийн Өлзийт сумыг дайран өнгөрч байгаа замын трасстай Жаст ойл ХХК-ийн шатахуун түгээх станцын барилга байгууламжийн талбай давхацсан, /АЗГ-ын 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 1/790 дугаар албан бичгээр Жаст ойл ХХК-нд газар чөлөөлөх тухай мэдэгдсэн/
- Геологийн судалгаа хангалтгүй хийснээс зам барилгын түүхий эдийн байршлыг зураг төсөлд буруу тусгаж өөр газраас тээвэрлэсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга байгууламжийн гүйцэтгэлд МХЕГ-аас хийсэн шалгалтын танилцуулгад геодезийн хэмжилт, геологийн хайгуулыг хангалтгүй гүйцэтгэснээс зураг төслийн өгөгдлүүд газар дээрээ зөрөх...Тухайлбал, Мон-Аз ХХК-ийн боловсруулсан Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай автозамын зураг төсөлд тусгагдсан далангийн өндрийн хэмжээ газар дээрээ 0,25-1м хүртэл зөрсөн...тухай дурдсан байна.

Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажлын захиалагчийн хяналтын хэсэгт 2009, 2010 онд хэмжилтийн, 2011 онд хэмжилтийн болон материалын инженер тус тус ажиллаагүй байна.

АЗГ-т байгаа объектын ажлын хавтаст 2008 оны 6, 8, 2009 оны 6, 7, 9, 10 дугаар саруудын хяналтын хэсгийн ажлын тайлан байхгүй, Баянхонгор аймгийн Өлзийт суманд байрлах хяналтын хэсэг дэх урьд онуудын тайлан үрэгдэж алга болсон зэрэг нь ажлын явц, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд хүндрэл учруулж байв.

Тус замын ажилд хяналт тавих захиалагчийн хяналтын хэсэг “Улсын төсөв, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажилд техник, технологийн хяналт гүйцэтгэх хяналтын хэсгийн ажиллах журам”-ын 5.1⁸, 5.14⁹-д заасныг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Арвайхээр- Баянхонгор чиглэлийн 50 км замын ажлыг шуурхай чанартай хийж, гэрээний үүргээ хэрэгжүүлэх талаар 28 удаа албан бичиг гүйцэтгэгчдэд хүргүүлж байсан ч хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үе шат тутамд захиалагчийн зүгээс тавих мэргэжлийн хяналтыг тогтмолжуулж, технологи, чанар, санхүүгийн сахилгыг өндөржүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хяналтын хэсгийн үндсэн зорилго бодитой үр дүнд хүрээгүй байна.

2.4 Гүйцэтгэгчийн ИТА-ны хангамж, ажлын явц, чанар, зохион байгуулалт хангалтгүй байжээ

Гүйцэтгэгч Улаанбаатар АЗЗА, Чайлган ХХК-ийн ажлын талбайд 3-6 инженер техникийн ажилтан дутуу ажилласан, ажиллаж байгаа инженерийн зарим нь мэргэжлийн шаардлага хангаагүй байжээ.

Мөн пикет хооронд өндрийн төвшин зөрүүтэй, хөрс хуулалт, автогрейдерийн тэгшилгээ дутуу хийгдсэн, далангийн нягтрал, асфальтбетон хучилтын нягтрал зэрэг технологийн горимын шаардлагыг баримтлаагүйгээс ажлын чанартай холбоотой доголдол гарч байжээ.

Түүнчлэн ажлын явц, техникийн бүрэн бүтэн байдал, цаг ашиглалт хангалтгүй, бутлуур, асфальтбетон заводыг шуурхай ажилд оруулах зэрэг ажлын зохион байгуулалттай холбоотой дутагдлууд хяналтын хэсгийн зарим тайланд дурдагджээ.



⁸ ...техникийн шаардлагын дагуу хяналт тавьж тухайн барилга, байгууламжийн чанарын өндөр түвшинд гэрээт хугацаанд нь ашиглалтад өгөх,

⁹ Хяналтын хэсэг нь барилгын ажлын явцын тухай тайлан, мэдээг батлагдсан загвараар сар бүр ...ирүүлж байна

Баянхонгор аймгийн аудитын газраас 2011 оны 3, 6, 9 дүгээр саруудад замын ажилтай танилцсан тухай тайланд, 2010 оны санхүүжилттэй нь гүйцэтгэсэн ажлын хэмжээг харьцуулахад бага, 7.8 км-т асфальтон хучилт хийсний 4.8 км нь чанар муу, замын ажил удаашралтай байсан боловч 9 дүгээр сард сайжирсан гэж дурджээ.

Мөн ҮАГ-аас Улаанбаатар АЗЗА ТӨХК-ийн 2010 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "...Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн замын барилга угсралтын ажлын орлогыг гэрээний үе шатанд гарсан зардалтай уялдуулан тайлагнаагүй ..." гэсэн үндэслэлээр хязгаарлалттай санал дүгнэлт өгчээ.

2.5 Худалдан авах ажиллагааг хангалтгүй зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг оройтож байгуулан, хөрөнгө оруулалтыг оновчгүй төлөвлөжээ

Баянхонгор-Арвайхээр чиглэлийн 27 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог ЗТАЖЯ/хуучнаар/-ны ТНБД-ын 2008 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 7 дугаар тушаалаар байгуулсан байна.

Энэ тендерт 7 аж ахуйн нэгж саналаа ирүүлж үнэлгээний хорооны хуралдаанаар Заавар ХХК-ийг 2 удаа, Өргөн говь ХХК, Монголын хурдны зам ХХК-иудыг шалгаруулсан боловч Сангийн яамнаас зөвшөөрөөгүй байна.

Улмаар Сангийн дэд сайдын 2008 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 9-11/3804 дугаар албан бичгээр Төв АЗЗА ТӨХК, Ялгуусан ХХК-ийн түншлэлийг шалгаруулж гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон байна.

Үнэлгээний хороо тендерийг муу зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээг оройтуулж байгуулснаас ажил эхлэх хугацаа хойшлогдсон байна.

Төв АЗЗА ТӨХК болон Ялгуусан ХХК-ийн түншлэл 5,265.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Арвайхээр- Баянхонгорын чиглэлийн 27 км хатуу хучилттай авто замын ажлыг 2008 оны 8 дугаар сарын 15-ны өдөр эхэлж, 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дуусгахаар ЗТАЖЯ-тай гэрээ байгуулсан байна.

Гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүйгээс 2010 оны 10 дугаар сарын 30, 2011 оны 10 дугаар сарын 31 хүртэл 2 удаа гэрээг сунгасан байна.

Захиалагч ЗТБХБЯ гүйцэтгэгчтэй 9.5 сарын хугацаанд замын барилгын ажлыг бүрэн гүйцэтгэж ашиглалтад оруулахаар гэрээ хийсэн ч 2008, 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийн 65.5 хувийг тусгаж батлуулсан байна.

сая төгрөгөөр

Төлөв лөсөн огноо	Хөрөнгийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэх хугацаа	Тухайн онд төлөвлөгдсөн хөрөнгө			Гүйцэтгэл
				Төсвийн төсөлд өгсөн санал	Батлагдсан төсөв	Төсвийн тодотголоор	
2008	МУХС	5,500.0	2008	5,000.0	1,000.0	5,500.0	178.1
2009	Улсын төсөв	5,500.0	2008- 2010	3,000.0	2,450.0	2,450.0	2,455.2

2010	Улсын төсөв	5,265.0	2008-2010	2,871.9	2,871.9	2,871.9	1,005.0
2011	Улсын төсөв	5,265.0	2008-2011	240.2	1,540.2		1,060.3

2008 онд тендер шалгаруулалт оройтож гэрээг хожуу байгуулсан тул төсвийн тодотголоор батлагдсан хөрөнгийн 3.2 хувийг зарцуулжээ.

2009 онд батлагдсан хөрөнгийн хэмжээнд ажлаа гүйцэтгэж санхүүжилтээ бүрэн авсан байна.

2010 онд графикт ажлаа дутуу гүйцэтгэж батлагдсан төсвөөс 1,005.0 сая төгрөгийг зарцуулаагүй, авсан урьдчилгаанаас 350.0 сая төгрөгийн өглөгтэй үлджээ.

Арвайхээр- Баянхонгорын чиглэлийн 27 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын үргэлжлэх хугацааг хөрөнгө оруулалттай уялдуулан ажил гүйцэтгэх гэрээ хийж төлөвлөөгүй, үнийн өөрчлөлтийн эрсдэлийг захиалагч, гүйцэтгэгчийн зүгээс урьдчилан тооцоогүй зэргээр уг ажил хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон байна.

2.6 Захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь хариуцлагагүй ажиллаж иржээ

Замын бэлтгэл ажилд захиалагч байгууллага хайнга хандсан, гүйцэтгэгч ажлын талбай дээр хүн хүч, машин техникээ хугацаанд нь байрлуулж ажлаа эхлүүлээгүй, олон ажил зэрэг гүйцэтгэснээс хүч тарамдан ажил удааширсан зэрэг дутагдлууд гарсан байна. Үүнд:

- Замын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны ажил хангалтгүйгээс 2008 оны 2 дугаар сарын 13-нд зарлагдсан тендерийн шалгаруулалт 3 удаа хүчингүй болсон ба Сангийн яамнаас 7 дугаар сарын 19-нд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвшөөрлийг өгсөн байна,
- Зам, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хугацаа алдаж хийснээс зөвшөөрлийг 2008 оны 9 дүгээр сарын 15-нд авснаар ажил 21 хоног хойшлогдсон /тухайн оны 8 дугаар сарын 29-нд батлагдсан төсвийг Автозамын хяналт судалгааны төвд ирүүлсэн, Өвөрхангай аймгийн Тарагт сумын засаг даргын 68 дугаар захирамжаар 9 дүгээр сарын 4-нд газар ашиглах зөвшөөрлийг олгосон/,
- Түншилгэгч Ялгуусан ХХК улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа энэ замын ажил болон Мөрөн Хатгалын 48,8 км, эргэн төлөгдөх нөхцөлтэй баригдсан Улаанбаатар хотын Бөмбөгөрийн зам, БНХАУ-ын Петрочайна Дайчин Тамсаг компанийн хөрөнгө оруулалтаар баригдсан Матад бичигт чиглэлийн 4 замд зэрэг ажиллаж улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа 2 гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.



Замын ажлын зураг төслийг зам гүүрийн зураг төслийн Эм Си Пи Си ХХК боловсруулсан бөгөөд зураг төсөлтэй холбоотой дараах алдаа, зөрчлүүд гарсан ч хариуцлага хүлээгээгүй байна. Үүнд:

- Замын трассын дагуу Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Арвайхээрийн талаас Баянхонгор чиглэлд ПК41+650 дээр 2008 оны 10 дугаар сарын 7-нд зураг төсөлд тусгаагдаагүй 2 хирээсүүр таарсныг ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй гэрээ байгуулж, 2009 оны 6 дугаар сарын 24-нөөс 7 дугаар сарын 14-ний дотор 12.4 сая төгрөгөөр археологийн дурсгалыг авран хамгаалах ажлыг гүйцэтгүүлсэн,
- Замын 28, 32.6, 29.6 км-т буюу ПК46+500, ПК32+200, ПК32+500, ПК31+850-32+000 хэсгүүдэд цахилгаан дамжуулах болон холбооны агаарын шугамууд замтай огтлолцсон хэсгүүдийн зай хэмжээг өөрчилсөн байна.

2008-2011 онд мэргэжлийн инженер дутагдалтайгаас захиалагчийн хяналтын хэсэгт хэмжилтийн инженер ажиллаагүй, хяналтын инженерт геодезийн инженерийн үүргийг хариуцуулан хавсран гүйцэтгүүлж байжээ.

АЗГ-ын гэрээний хэрэгжилт хариуцсан инженерийн хяналтын хэсгийн 2009 оны 8, 9 дүгээр сар, 2010 оны 6, 8, 9, 10 дугаар сарын ажлын тайлангууд батлагдсан журмын дагуу бичигдээгүй, бүрэн бус байгаа нь “Улсын төсөв, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажилд техник, технологийн хяналт гүйцэтгэх хяналтын хэсгийн ажиллах журам”-ын 5.14¹⁰-д заасныг зөрчсөн байна.

Захиалагчийн хяналтын хэсгээс 2009-2011 онд гүйцэтгэгч компанид өгсөн хяналтын инженерийн албан шаардлагыг түүвэрлэн үзүүлбэл:

Хяналтын инженерийн өгсөн албан шаардлагын агуулга	2009 он	2010 он	2011 он	Бүгд	
				тоо	Дүнд эзлэх хувь
Ажлын зохион байгуулалт, цагийн хуваарь, ажил эрчимжүүлэх	8	2	3	13	20.0
Ажлын төлөвлөгөө, график, тайлангийн талаар	8		2	10	15.4
Гүйцэтгэсэн ажлын чанар	11	3	2	16	24.6
Лабораторийн шинжилгээний талаар	4	3		7	10.8
Түүхий эд, бусад нөөцийн талаар	4	3	1	8	12.3
Бусад	10	1		11	16.9
Дүн	45	12	8	65	100.0

¹⁰ Хяналтын хэсэг нь барилгын ажлын явцын тухай тайлан, мэдээг батлагдсан загвараар сар бүр ...ирүүлж байна

Хүснэгтээс харахад 2009-2011 онд гүйцэтгэгчийн ажлын зохион байгуулалт хангалтгүй, эрчимжүүлэх, чанарын доголдолтой холбоотой өгсөн албан шаардлага нийт дүнд 60.0 хувийг эзэлж байгаа нь гүйцэтгэгчийн ажил доголдолтой, хариуцлага сахилга сул байсныг харуулж байна.

2009 онд буюу ажил эхлэн эрчимтэй явагддаг эхний жилд, замын барилгын болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд олон асуудал гарч хяналтын хэсгээс нийт хугацааны албан шаардлагын 69.2 хувийг өгсөн байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн материалын боловсруулалт хангалтгүй, гүйцэтгэгчийг зөв сонгон шалгаруулаагүйгээс тендер оройтож, ажил эхлэх хугацаа хойшилсон байна.
2. Тендерийн баримт бичгийг компаниуд худалдан авдаг боловч тендер ирүүлдэггүй нь автозамын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй үндэсний компаниудын өрсөлдөх чадвар сул байгаатай холбоотой байна.
3. Тендерийн материалын бүрдэл хангалтгүй, архивын нэгж болгон хадгалаагүй, зарим тендерийн материал олдохгүй байна.
4. Үүнийн өсөлтөөс үүсэх эрсдэлийг судалж тооцоолоогүй, төсөвт өртгийн хэмжээнд тохируулан үндэслэл муутай үнийн санал ирүүлж тендерт шалгаран гэрээ байгуулсан нь хугацаандаа ажлаа гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлжээ.
5. ТБОНӨХБАҮХАТухай хууль болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний “үнийн тохируулга хийх” тухай заалтыг хэрэгжүүлэх механизм бүрдээгүйгээс авто зам ашиглалтад орохгүй ихээхэн хугацаа алдаж хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч байна.
6. Зам барилгын ажил, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдаагүй, гүйцэтгэгч компаниуд хэд хэдэн зам дээр зэрэг ажиллаж хүч тарамдуулдаг, ажлын зохион байгуулалт, инженер, техникийн ажилтнуудын болон техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, бэлэн байдал, ажлын чанар хангалтгүй, график, төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүйгээс дээрх замууд хугацаандаа ашиглалтад ороогүй байна.
7. Захиалагч АЗГ-т мэргэжлийн инженер цөөн, захиалагч өөрөө технологийн хяналт хийж байгаа өнөөгийн арга хэлбэр шаардлага хангахгүй байгаагаас захиалагчийн хяналтын үр нөлөө хангалтгүй байна. Харин төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр баригдаж байгаа Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 3 дугаар ээлжийн 143 км авто замын захиалагчийн хяналтыг зөвлөх компани хэрэгжүүлж байгаа нь үр дүнтэй болж байна.
8. Авто замын зураг төсөл чанаргүй хийгдсэнээс ажлын явцад өөрчлөлт оруулах, түүнээс шалтгаалан ажил саатаж удаашрах, төлөвлөгдөөгүй ажлууд нэмэгдэх явдал гарсан атал захиалагч байгууллагаас холбогдох арга хэмжээг шуурхай авч, зураг төслийн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад:

1. ТБОНӨХБАҮХАТухай хууль болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний “үнийн тохируулга хийх” тухай заалтыг хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх асуудлыг судлан, холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх
2. Төсвийн норм, үнэлгээг шинэчлэн боловсруулж мөрдөх,
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний хөрөнгийг зам, барилгын ажил гүйцэтгэх хугацаа, гэрээний нөхцөл, барилгын норм, дүрмийг мөрдөн оновчтой төлөвлөж байх,
4. Тендерийн баримт бичигт гүйцэтгэгчийн хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээллийг ирүүлэх нөхцөл заалт оруулах, компанийн бодит хүчин чадлыг зөв үнэлж сонгон шалгаруулалт явуулж байх,
5. Үнэлгээний хорооны ажлыг үнэлж, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивын нэгж болгон хүлээлгэж өгөөгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.
6. Гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн барилгын болон зураг төслийн гүйцэтгэгч байгууллагуудад гэрээний дагуу хариуцлага тооцож захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах,
7. Авто замын зураг төсвийн ажлын чанар, түүнд хяналт тавьж магадлал хийдэг мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, одоогийн тогтолцоог боловсронгуй, үр дүнтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Авто замын газрын дарга Б.Энхтөрд:

1. Эргэн төлөгдөх нөхцлөөр хэрэгжүүлж буй Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 143 км авто замын ажлын явцыг эрчимжүүлж, технологийн дагуу чанартай гүйцэтгүүлэх.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АВТО ЗАМЫН ГАЗАР

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө 11, Утас/Факс: (976-11) 31-05-03,
E-mail: road@mongol.net, http://www.mongolroad.mn

2011.12.15 № 1/1497

танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ

Өвөрхангай-Баянхонгор, Өндөрхаан-Чойбалсан
чиглэлд баригдаж байгаа авто замын ажилд хийсэн
шалгалтын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй санал нэг байна.

ДАРГА



Б.ЭНХТӨР



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2011 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын чанартай зарим авто замын ажлын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2.Аудитаар тавьсан төлбөрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газарт хүргүүлсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрын дарга Б.Энхтөр нарт зөвлөсүгэй.

5.Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, тавьсан төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.


МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070381
tushaal

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2011 оны
12 дугаар сар 21-ны өдрийн 134 дугаар
тушаалын хавсралт



Төлбөрийн жагсаалт

Төлбөрийн актын агуулга	Хариуцах эзэн	Төлбөрийн дүн
Урьдчилгаа төлбөрийг буцаан төвлөрүүлэх тухай	Насны зам ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Болормаа	1 874 678 161 (Нэг тэрбум найман зуун далан дөрвөн сая зургаан зуун далан найман мянга нэг зуун жаран нэгэн төгрөг)

tushaal